



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,

Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,

Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,

E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

БАТЛАН ХАМГААЛАХ, ХУУЛЬ
САХИУЛАХ АЛБА ХААГЧДЫН
НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРАГЧ,
ЕРӨНХИЙ ЭМЧ ХУРАНДАА
С.БАТБОЛД ТАНАА

2017.02.22 № 3/326
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.


Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



БАТЛАН ХАМГААЛАХ, ХУУЛЬ САХИУЛАХ АЛБА ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг:
naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261740
Цахим хаяг:
gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор: Ж.Батсайхан
batsaikhanj@audit.gov.mn

Аудитор: Ш.Отгонбаяр
Утас: 261885
Цахим хаяг:
Otgonbayarsh@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: Үндэсний аудитын
газар
Байршил: 3Г-ын 4-р байр
Чингэлтэй дүүрэг
Цахим хуудас: www.audit.mn

Хавсралт 1: Агуулга
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
Хавсралт 3: Менежментийн захидал
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

2017 оны 2 дугаар сар

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дэх заалтыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. САГ-2017/153/СТА-ТШЗ/

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төсвийн захирагчийн 2016 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ҮАГ-ын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ж.Батсайхан, аудитор Ш.Отгонбаяр хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төсвийн захирагч 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 24-ний өдөр 165 тоот албан бичгээр Үндэсний аудитын газар ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар тус эмнэлгийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 2 дугаар сарын 16-наас 2017 оны 2 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 25-нд байгууллагын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол Улсын Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчид болон Баянзүрх дүүргийн иргэдийн ая тухтай эмчлүүлэх орчинг бүрдүүлж, түргэн шуурхай үйлчлэх. Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн бие бүрэлдэхүүний нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, цалин, тэтгэмж, томилолт, хувцас, техник, тоног төхөөрөмж, хүнсний хангалтыг хийж, бие бүрэлдэхүүнд үйлчлэх чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлд улс орныг батлан хамгаалах арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Дээрх хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-д батлан хамгаалах чадавх нь улсын эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, боловсрол, төрийн цэргийн байгууллагын чадавх, хүч нөөцөөр хангагдана гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4-д заасны дагуу Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг Батлан хамгаалах яамнаас олгож байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой заавар, журам хуулиудыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын 4, нарийвчилсан 4 сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад төсвийн шууд захирагчын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хууль тогтоомж, журам, заавартай нийцүүлэх.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа нягтлан бодох бүртгэлийн цахим програмтай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төсвийн шууд захирагч санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “ACOULIS” бүртгэлийн санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Материаллаг байдал:

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийг тогтоохдоо үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 2 хувиар тооцож, материаллаг байдлын түвшинг 277.8 сая төгрөгөөр тогтоов.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, батлагдсан төсвийн хуваарийн дагуу төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлын зүйл ангиллаар хуваарилан төсвийн гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Тайлант онд 5,351.1 сая төгрөгийг улсын төсвөөс, эрүүл мэндийн даатгалын сангаас 5,085.7 сая, үндсэн үйл ажилгааны орлого 592.6 сая, нэмэлт төсвийн дансаар 345.5 сая, нийгмийн даатгалын сангаас тэтгэмж 50.7 сая, нэр данс зөрүүтэй гүйлгээ 3.1 сая, нийт 11,428.7 сая төгрөгийн орлого орсон байна. Үүнээс цалинд 6,384.6 сая, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлд 581.6 сая, тогтмол болон урсгал зардал 4,462.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Бараа материал:

Тайлант хугацаанд төсвөөс 2,744.4 сая төгрөгийн бараа материал худалдан авсан, ЗХ-ний 310 дугаар ангиас хангалтаар 1,683.8 сая, хандив тусламжаар 1,261.2 сая, шилжүүлэн авсан болон бусад 983.8 сая, нийт 6,673.2 сая төгрөгийн бараа материалын тодруулга тайлангаар нэмэгдсэн.

Батлан хамгаалахын сайдын 2016 оны А/312 тоот тушаалаар эмнэлэгт 89.9 сая төгрөгийн бараа материалыг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт хүлээлгэн өгсөн.

Үндсэн хөрөнгө:

Тайлант онд төсвөөс 512.3 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан ба, гадаадын зээл, тусламжаар 592.8 сая, шилжүүлэн авсан бүтцийн өөрчлөлтөөр 1,618.8 сая, бусад эх үүсвэрээс 13.4 сая, нийт 2,737.3 сая төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн. БХС-ын 2016 оны А/312 дугаар тушаалаар 884.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт балансаас балансад шилжүүлсэн.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд хяналтын 4, нарийвчилсан 4 нийт 8 горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний зардлын 100.0 мянган төгрөгөөс дээш дүнтэй 98 ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн. Үүнд:

1. Жижиг мөнгөн сангийн жилийн дүүргэлтээр нийт 10.9 сая төгрөг, кассанд орлого авсан. Кассын тайлангаар 11.1 сая төгрөг зарцуулсан ба хувь хүнээс бараа худалдан авсны татварын суутгалд 0.2 сая төгрөг, кассын орлогоос зарцуулсан зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн: Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалд төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журамын 3.13-д эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын өдрийн 1 хоногт багтаан тушаана гэж заасныг зөрчсөн. Менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

2.Тус эмнэлэг нь санхүүгийн тайлангаар 0.9 сая төгрөгийн авлагатай гэж тайлагнасан боловч төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Шийдвэрлэсэн: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэж заасныг зөрчсөн. Менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

3. Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй байна гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана гэж заасныг зөрчсөн. Менежментийн захидлаар зөвлөмж өгөх.

4. Бэлэн бүтээгдэхүүн, хангамжийн материал мал амьтад, дуусаагүй үйлдвэрлэл, мөнгөн гүйлгээний тайлан, богино хугацаат өр төлбөр, нийт 887.6 сая төгрөгөөр бараа материалын тодруулга тайлан нь санхүүгийн байдлын тайлантай зөрүүтэй тайлагнасан.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг, алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна...мөн 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна гэж заасан. Санхүүгийн дарга, нягтлан бодогч хүлээн зөвшөөрч залруулга хийлээ.

Материаллаг бүс залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц асуудал байхгүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал тус эмнэлгийн барилга барих гүйцэтгэгчийг БХЯ-ны тендерийн хороо шалгаруулж, 2011 онд эмнэлгийн шавийг тавьж, 2013 онд ашиглалтанд орох төлөвлөгөөтэй байсан. 2016 оны 6 дугаар сард Улсын комисс хүлээн авч, ашиглалтанд орсон ба эмнэлгийн барилгыг гүйцэтгэгч байгууллага тухайн үеийн материалын үнээр тооцсон гэсэн маргаантай, мөн Батлан хамгаалах сайдын тушаал гараагүйгээс өнөөг хүртэл данс бүртгэлд аваагүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 888.7 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч, үүнээс 887.6 сая төгрөгийн санхүүгийн тайланд залруулга хийж, 1.1 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгөх.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 2 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, ҮАГ-т биелэлтийг гарган ирүүлсэн байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

БАТЛАН ХАМГААЛАХ, ХУУЛЬ САХИУЛАХ АЛБА ХААГЧДЫН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТӨСВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 1

Жижиг мөнгөн сан

Асуудал 2

Авлага

Асуудал 3

НБББББ

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг Төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Батлан хамгаалах, хууль сахиулах алба хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирагч, болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

Жижиг мөнгөн сангийн жилийн дүүргэлтээр авсан 10.9 сая төгрөг, кассанд орлого авсан. Кассын тайлангаар 11.1 сая төгрөг зарцуулсан ба хувь хүнээс бараа худалдан авсны татварын суутгалд 0.2 сая төгрөг, кассын орлогоос зарцуулсан зөрчил илэрлээ.

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалд төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журамын 3.13-д эрх бүхий ажилтан хураасан орлогоо өөрийн байгууллагын бүртгэлийн дансанд ажлын өдрийн 1 хоногт багтаан тушаана гэж мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 9 дүгээр сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэл

Бүртгэлээр тавих, дотоод хяналт алдагдах.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Тус эмнэлэг нь санхүүгийн тайлангаар 0.9 сая төгрөгийн авлагатай гэж тайлагнасан боловч төрийн сантай тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх талаар мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 9 дүгээр сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэл

Хөрөнгө үрэгдэх, дотоод хяналт алдагдах.

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ҮАГ-ын ажиглалт

Тус байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй байна гэж заасныг зөрчсөн.

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-д Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2017 оны 9 дүгээр сарын 30-ны дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэл

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, стандарт, дүрэм, журам, бүртгэлээр тавих хяналт алдагдах,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн шууд захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

АУДИТ ХИЙСЭН 2016 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,087,891,492.65	10,222,208,365.70	11,263,245,128.00	11,428,756,788.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,087,891,492.65	10,222,208,365.70	11,263,245,128.00	11,428,756,788.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	9,668,665,100.00	9,492,973,056.00	10,903,245,128.00	10,952,202,474.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,645,375,600.00	6,645,375,600.00	6,384,675,581.00	6,384,675,580.00
210101	Үндсэн цалин	6,645,375,600.00	6,645,375,600.00	3,915,697,339.00	3,915,697,339.00
210102	Нэмэгдэл			2,468,978,242.00	2,468,978,241.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	467,284,900.00	462,584,900.00	581,609,700.00	581,609,700.00
210201	Тэтгэврийн даатгал	273,639,100.00	285,128,500.00	351,549,300.00	351,549,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	31,585,600.00	28,953,500.00	26,668,300.00	26,668,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	39,476,100.00	36,186,400.00	33,329,500.00	33,329,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,895,500.00	7,237,500.00	6,666,200.00	6,666,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	114,688,600.00	105,079,000.00	163,396,400.00	163,396,400.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	358,676,100.00	326,425,966.00	399,411,900.00	399,411,618.33
210301	Гэрэл, цахилгаан	109,774,200.00	121,725,362.00	193,666,800.00	201,822,912.00
210302	Түлш, халаалт	179,214,700.00	118,302,266.00	123,960,400.00	113,086,778.00
210303	Цэвэр, бохир ус	69,687,200.00	86,398,338.00	81,784,700.00	84,501,928.33
210304	Байрны түрээс				
2104	Хангамж, бараа материалын зардал	95,511,900.00	95,511,900.00	123,274,773.00	123,274,773.00
210401	Бичиг хэрэг	25,655,400.00	20,246,230.00	20,900,800.00	16,159,499.36
210402	Тээвэр, шатахуун	27,888,700.00	28,054,270.00	64,918,473.00	64,918,473.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,752,200.00	5,720,198.00	3,336,400.00	3,223,797.64
210404	Ном, хэвлэл		939,100.00		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	31,716,600.00	38,094,232.00	28,499,500.00	33,478,050.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,499,000.00	2,457,870.00	5,619,600.00	5,494,953.00
2105	Нормативт зардал	1,928,250,000.00	1,928,250,000.00	2,556,602,249.00	2,552,827,499.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,401,472,000.00	1,395,487,445.00	1,942,325,582.00	1,919,523,447.00
210502	Хоол, хүнс	450,000,000.00	449,515,217.00	476,676,267.00	458,192,952.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	76,778,000.00	83,247,338.00	137,600,400.00	175,111,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,085,600.00	25,986,580.00	835,692,625.00	835,692,625.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,490,000.00	2,006,500.00	706,590,825.00	706,590,844.00
210602	Тавилга		487,780.00		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл			10,853,000.00	10,853,000.00
210604	Урсгал засвар	28,595,600.00	23,492,300.00	118,248,800.00	118,248,781.00
2107	Томилот, зочны зардал	1,745,000.00	140,000.00	-	-
210702	Дотоод албан томилолт	1,745,000.00	140,000.00		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,700,000.00	7,307,210.00	17,096,600.00	69,829,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,500,000.00	7,287,710.00	15,451,600.00	14,951,600.00
210803	Даатгалын үйлчилгээ				50,720,638.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		18,000.00		
210807	Газрын төлбөр	200,000.00		1,500,000.00	1,500,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж		1,500.00	145,000.00	145,000.00
210818	Бусад мөнгөн зарлага /ТӨҮГ/				2,511,762.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	136,036,000.00	1,390,900.00	4,881,700.00	4,881,679.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	134,550,000.00			
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,486,000.00	1,390,900.00	4,881,700.00	4,881,679.00
212	ТАТААС	-	307,584,839.40	-	117,407,653.67
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	-	307,584,839.40	-	117,407,653.67
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас		307,584,839.40		117,407,653.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	419,226,392.65	421,650,470.30	360,000,000.00	359,146,660.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	419,226,392.65	421,650,470.30	360,000,000.00	359,146,660.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	112,020,000.00	112,019,464.00	10,000,000.00	9,146,660.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	70,041,492.65	67,868,085.30		
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	226,046,300.00	235,619,921.00	350,000,000.00	350,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,118,600.00	6,143,000.00		
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,087,892,392.65	10,222,208,365.70	11,263,245,128.00	11,428,756,788.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,757,481,000.00	4,739,688,300.00	5,351,884,100.00	5,351,050,700.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,757,481,000.00	4,739,688,300.00	5,351,884,100.00	5,351,050,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого			345,591,128.00	345,591,128.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө			37,242,000.00	37,242,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого			308,349,128.00	308,349,128.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	-	-	-	-
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,960,369,900.00	4,960,369,900.00	5,085,769,900.00	5,136,490,538.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих				50,720,638.00
134003	Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт	4,960,369,900.00	4,960,369,900.00	5,085,769,900.00	5,085,769,900.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	370,041,492.65	522,150,165.70	480,000,000.00	595,624,422.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	300,000,000.00	447,126,093.05	480,000,000.00	592,572,660.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	70,041,492.65	4,982,580.00		540,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих		70,041,492.65		

1200009	Бусад орлого				2,511,762.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	1.00
610002	Төсвөөс гадуур байгууллага				
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	728.00	660.00	728.00	660.00
620001	Удирдах ажилтан	4.00	4.00	4.00	4.00
620002	Гүйцэтгэх ажилтан	338.00	284.00	338.00	284.00
620003	Үйлчлэх ажилтан	386.00	372.00	386.00	372.00
620004	Гэрээт ажилтан				